



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 24 өдөр

Дугаар А/510

Чингис хот

Тусгай зөвшөөрөл сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.5, 6 дугаар зүйлийн 6.2, 14 дүгээр зүйлийн 14.1.1, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.7, 6 дугаар зүйлийн 6.3 дахь заалтууд, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 03 дугаар тогтоолоор батлагдсан "Согтууруулах, ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгох, хяналт тавих журам"-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дараах аж ахуйн нэгжүүдийн согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг 2020 оны 09 дүгээр сарын 29-ний өдрөөс эхлэн хоёр жилийн хугацаатай сунгасугай.

Хүнсний дэлгүүр:

1. Хэрлэн сум - "ДЭНХЦ" ХХК
2. Хэрлэн сум - "Их Баян Бараат" ХХК
3. Баянхутаг сум - "Гурван номгон" ХХК
4. Галшар сум - "Алтат ам" ХХК

Баар:

1. Хэрлэн сум - "Ихэр гэрэл" ХХК
2. Хэрлэн сум - "Хурах эрдэнэ" ХХК

2. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг согтууруулах ундааны үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ эрхлэхэд хяналт тавих аймгийн комиссын дарга /Ц.Чогсомжав/, Цагдаагийн газар /Цагдаагийн хурандаа Б.Батсайхан/, Мэргэжлийн хяналтын газар /С.Сүнгээ/, Стандарт, хэмжилзүйн хэлтэс /Ч.Пүрэвдорж/, Татварын хэлтэс /А.Гантөмөр/, холбогдох сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Энэхүү захиргааны актыг хүлээн зөвшөөрөхгүй тохиолдолд албан ёсоор гардаж авснаас хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх эрх бүхий байгууллагад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231011119